

ТАЙЛАН

"Монголиан Эйрвейс Карго" ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 29-ний 23/524 дугаартай албан бичгээр ирүүлсэн нойтон түрээсийн гэрээний нөхцөлөөр Бүгд Найрамдах Армени Улсын "Flyone Armenia" агаарын тээврийн компанийн нислэгийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийсэн тайлан.

НСҮАХХ-ийн 2024 оны төлөвлөгөөт үзлэг шалгалтын хүрээнд Армени Улсын FLYONE ARMENIA LLC компанид нойтон түрээсээр үйл ажиллагаа гүйцэтгэж буй "Монголиан Эйрвейс Карго" ХХК-д Иргэний нисэхийн дүрмийн хүрээнд үзлэг шалгалтыг "Operational inspector Surveillance Manual" зааврын дагуу дараах чиглэлээр үзлэг шалгалтыг гүйцэтгэсэн.

- Flight deck enroute inspection Job Aid OP-003, Flight deck ramp inspection Job Aid OP-005, Cabin ramp inspection Job Aid OP-006 хяналтын хуудсын дагуу 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр UDYZ-LUKK-UDYZ нислэгийн чиглэлд хяналт шалгалтыг хийсэн.
- Flight preparation records inspection Job Aid OP-010 хяналтын хуудсын дагуу дараах нислэгийн бичиг баримтыг шалгасан. Үүнд:

2023 оны 12 дугаар сарын 21-ний FOE 871/872;

2023 оны 12 дугаар сарын 24-ний FOE 475/476;

2023 оны 12 дугаар сарын 31-ний FOE 533/534;

2023 оны 11 дүгээр сарын 20-ны FOE 245/246;

2023 оны 11 дүгээр сарын 19-ний FOE 871/872 дугаартай нислэгүүдийн гүйцэтгэлийг шалгахад дараах үл нийцэл илэрсэн.

Дээрх нислэгүүдийг Нислэг хяналтын мэргэжилтэн нь баталж байгаа нь 119.71 болон 119.51(b)(1)(i) дүрэмд шаардсан, нисэх багийг бүрдүүлэхэд танилцах болон зөөлтийн нислэг үйлдэж байгаа нисгэгч нь багш нисгэгчтэй томилон нислэг үйлдэж байгаа нь 121.505(a)(2), 121.509(3) дүрмүүд болон Иргэний нисэхийн тухай хуулийн 17.5. "Бүрэн бус бүрэлдэхүүнтэй нисэх баг нислэг үйлдэхийг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчиж үйл ажиллагаа явуулж байна.

Мөн тус компани нь 8 дугаар сард 376.3, 9 дүгээр сард 378.1 цаг, 10 дугаар сард 306.4 цаг, 11 дүгээр сард 124.3 сард тус тус ниссэн байгаа боловч нисэх багийн нислэгийн цаг, нислэгийн үүрэг гүйцэтгэх хугацаа, нислэгийн өмнөх амралтын хугацаа зэргийг хянах тогтолцоо бүрдээгүй байгаа нь 121.803(a)(1),(b),(c)(1) дүрмийн хэрэгжилт хангалгүй байна.

- Ground Handling Station inspection Job Aid OP-017 хяналтын хуудсын дагуу шалгахад газрын үйлчилгээг Aircraft wet lease agreement-Mongolian Airways Cargo LLC and FLY ONE Armenia LLC компанийн хооронд байгуулсан гэрээний дагуу газрын үйлчилгээ IATA стандартын дагуу гүйцэтгэж байна.
- Operational control inspection Job Aid OP-012 хяналтын хуудсын дагуу үзлэг шалгалтыг 2024 оны 01 дүгээр сарын 06-07-ны өдрүүдэд тус компанийн нислэгийн хяналтын диспетчир Хэрлэнтэй уулзаж ажлын байранд гүйцэтгэсэн. Нислэгийн дагалдах үйлчилгээ, нислэгийн өмнөх бэлтгэл, бичиг баримтын хангалтыг гэрээний 12.3, 11.2 с) заалтын дагуу түрээслэгч нь PPS програмд хийж түрээслэгч компанийн Dispatcher office - руу цахим хаягаар шилжүүлж зохицуулалтыг хийж байна. Харин хяналт шалгалтын явцад тус компанийн нислэгийн төлөвлөлтийн дэлгэрэнгүй тайлбар (Operation Flight Plan) байхгүй байгаа бөгөөд цаашид зохих зааварт мэдээллийг оруулах шаардлагатай байна.

Иймд үзлэг шалгалтын үр дүнд илэрсэн үл нийцлийг залруулан ажиллахыг албан бичгээр тус компанид хүргүүлсэн.

Тайлан бичсэн НСҮАХХ ахлах байцаагч Х.Эвсанаа